

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ТУЛГАМДАЖБУЙ АСУУДАЛ

Түлхүүр үг: Эрсдэл, эрсдэлийн удирдлага, шинжилгээ, шүүхийн шинжилгээний байгууллагын эрсдэлийн удирдлага

Удиртгал Байгууллага бүр эрсдэлтэй нүүр тулж байдаг. Энгийнээр хэлбэл эрсдэлийг удирдах олон аргуудаас тохиромжтойг нь сонгож, хамгийн бага зардлаар байгууллагын эрсдэлийг бууруулах арга хэмжээ бол эрсдэлийн удирдлага юм.

Эрсдэл нь тухайн байгууллагын онцлог зорилго, зорилтуудыг хангахад учирч болох нөлөөлөл гэж ойлгож болно. Эрсдэлийн удирдлага буюу “risk management” гэсэн нэр томьёо харьцангуй хожуу бий болсон байна.

Монгол Улсын шинжлэн магадлах салбарын эрсдэлийн менежмент нь түүхэн хугацааны туршид хувь хүний чадамжид тулгуурласан шинжтэй хөгжиж ирсэн нь практикаас харагддаг.

2013 оноос шүүхийн шинжилгээний байгууллагад эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх нэгж ажиллах болсон нь эрсдэлийг цогц байдлаар урьдчилан тодорхойлох, үнэлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн алхам болсон байна. Гэвч шинэ тутам байгуулагдсан тус нэгжийн үйл ажиллагаа түүний үр дүнгээс дүгнэлт хийхэд эрсдэлийн удирдлагын сонгодог утга болсон “ирээдүйг тааварлах” гэхээсээ илүү эрсдэл учирсны дараа арга хэмжээ авах байдлаар явагдаж иржээ.

Энэ нь шинжлэн магадлахуйн эрсдэлийн менежментийн тогтолцоог зөв бүрдүүлэх үндэс суурь болох судалгааны ажил бараг хийгдээгүйтэй холбоотой байж болох юм. Иймд “Шүүхийн шинжилгээний байгууллагын эрсдэлийн удирдлага, тулгамдаж буй асуудал” сэдвийг сонгон авч судалгааны хүрээнд шүүхийн шинжилгээний байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, тэдгээрийг шийдвэрлэх арга, ажиллагааны талаар боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорилоо.

Эрсдэл ба эрсдэлийн удирдлага

¹ Эрсдэлийн удирдлагын чиглэлээр нэлээд судлагдсан боловч ихэвчлэн улс орны аюулгүй байдал, улс төр, эдийн засгийн, уул уурхай, банк, санхүүгийн салбарт түлхүү судлагдсан байна. Монгол Улсад 2000 оноос мэдлэгийн энэхүү салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах, практикт нэвтрүүлэх ажил хийгджээ. Ихэвчлэн санхүү, даатгал, үндэсний аюулгүй байдал, гамшиг судлалын чиглэлээр. эрсдэлийн менежментийг судалсан байх бөгөөд “Мандал даатгал”-ын “Эрсдэлийн удирдлага” УБ., 2016 он, Худалдаа Хөгжлийн банк “Банкны эрсдэл”, Сангийн яамны “Байгууллагын эрсдэлийн удирдлагад дотоод аудитыг нэвтрүүлэх” УБ., 2015 он зэрэг ном, бүтээл туурвисан байна.

Эрсдэл буюу risk хэмээх нэр томъёог зарим тайлбар толь бичгүүдэд “байж болох, учирч болох аюул”, “ээрэг үр дүнтэй болно гэж найдах”, “эрсдэх гэдэг нь юу ч тохиолдсон бүхий л хариуцлагыг өөртөө хүлээх” гэх зэргээр тайлбарлан бичсэн байна. Тухайлбал, Н.Уэбстерын Англи хэлний тольд “аюул, болзошгүй алдагдал буюу хохирол”, Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбарт “болзошгүй аюул”, Эдийн засгийн дэлгэрэнгүй тольд “тодорхой ажиллагааны буюу шийдвэрийн үр дүнд сөрөг үр дагавруудтай үйл явдал эхлэх боломж” гэх мэтээр тайлбарласан байна.

Эрсдэлийн менежмент нь ямар нэгэн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг таньж тогтоох, тэдгээрт дүн шинжилгээ хийх, эрсдэлтэй харьцах, мониторинг хийх зүй тогтол юм.

Эрсдэлийн менежментийн процессыг бүрдүүлж буй алхмууд (RM process steps) нь бизнесийн төрлөөс үл хамааран аливаа байгууллагын жанжин шугам нь (generic guide) болдог. Эдгээр алхмыг дурдвал,

Нөхцөлийг (аргуулгыг) тодорхойлох (Establish the Context);

Эрсдэлийг таньж тогтоох (Identify Risks);

Эрсдэлд дүн шинжилгээ хийх (Analyze the Risks);

Эрсдэлд үнэлгээ өгөх (Evaluate the Risks);

Эрсдэлтэй харьцах (Treat the Risks);

Мониторинг хийх ба үр дүнг хянан үзэх (Monitoring and Review);

Санал авах, зөвлөлдөх (Communication and Consultation).

Эрсдэлийн онолын судалгаа нь үндсэндээ 1/ эдийн засгийн шинжлэх ухааны талаас эрсдэл тохиолдох магадлалыг тодорхойлох, хэмжих арга зүй, 2/ удирдлагын шинжлэх ухаан талаасаа эрсдэлийг тодорхойлох, бууруулах, удирдахыг судлах гэсэн чиглэлд хийгдэж, хөгжиж ирсэн.

Аливаа байгууллага нийгмийн хүрээлэн буй орчны, технологийн аюулгүй байдал, хамгаалалтын болон санхүү, эдийн засгийн талаар тавьсан зорилтдоо хүрэх үйл явцыг тодорхой бус болгодог дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөлөлтэй тулгарч байдаг. Байгууллагын үйл ажиллагааны энэхүү тодорхой бус байдлын үр дагаврыг “эрсдэл” гэж үздэг ба байгууллагын бүхий л үйл ажиллагаа эрсдэлийг дагуулж байдаг.

Орчин үед байгууллагууд өөрийн онцлог, чадамжинд тулгуурлан зохих хэмжээнд эрсдэлээ удирдаж байгаа боловч эрсдэлийн удирдлагыг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарсаар л байна.

Эрсдэлийг зөв удирдсанаар аюулыг тодорхойлон, урьдчилан харж, арга хэмжээ авснаар зөвхөн боломжит алдагдлыг бууруулаад зогсохгүй шинэ боломж, нөөцийг олгож, хяналт сайжрахаас гадна үйл ажиллагааны үр дүнтэй байдал нэмэгддэг. Түүнчлэн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь байгууллагын холбогдох хууль тогтоомж, зохицуулах норм, дүрэм, журмын нийцлийг сайжруулахаас гадна зөв, зохистой шийдвэр гаргах болон төлөвлөх, нөөцийн хуваарилалтыг үр ашигтай хийх боломжийг олгодог.

Олон улсад “эрсдэлийн бүртгэлийг” хөтөлж, үүнд эрсдэлийг үүсгэж буй аюул, эх үүсвэр, магадлал болон үр дагавруудыг тодорхойлж өгдөг байна.

Эрсдэлийг тодорхойлох олон аргууд байдаг бөгөөд хамгийн энгийн эх сурвалж нь өмнө учирч байсан аюул, эрсдэлийг бичиж тэмдэглэх явдал байдаг. Эдгээр мэдээллийг аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санхүүгийн хохирлын талаарх мэдээлэл, үйл ажиллагаанд учирсан нөлөөлөл, хохирол, алдаа, дутагдалд дүн шинжилгээ хийх замаар тодорхойлж болно.

Эрсдэлүүдээ тодорхойлж, үнэлж, дүгнэсний дараа байгууллага хамгийн эрсдэл ихтэйгээс нь эхлэн эрсдэл бүрд нийцэх түүнээс зайлсхийх, бууруулах, багасгах бусад шийдлүүдийг олох, эрсдэлийг хуваах, шилжүүлэх арга хэмжээг авах, эсхүл эрсдэлийг хүлээн зөвшөөрдөг.

Байгууллагын эрсдэлийн хяналт, тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хүлээн зөвшөөрөгдсөн, түгээмэл ашиглагддаг үндсэн загвар нь олон улсын стандартын байгууллагын ISO 31000:2009 - Эрсдэлийн удирдлага - Зарчим ба заавар стандарт¹ юм. Монгол Улсын хэмжээнд төрийн байгууллагууд энэхүү стандартын дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхээр зорин ажилладаг.

Шүүхийн шинжилгээний байгууллагын эрсдэлийн удирдлага

Шүүх шинжилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны салбар, чиглэлтэй холбоотой судалгааны ажлууд цөөнгүй хийгдэж, тус салбарт тулгамдаж буй асуудал, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохыг хичээж байна. Тухайлбал 2009 онд АНУ-ын Үндэсний шинжлэх ухааны академи (National Academy of Science) нь АНУ-д шүүх шинжилгээг бэхжүүлэх чиглэлээр нэгэн судалгааг хийсэн нь дэлхий дахинд шүүх шинжилгээний салбарын дэд бүтцийн асуудалд анхаарал хандуулах шаардлагатай талаар асуудал дэвшүүлсэн². Судалгааны тайланд: “Конгресс бие даасан холбооны этгээд болох шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнг үйл ажиллагаагаа явуулахад хангалттай санхүүжилтээр хангах шаардлагатай бөгөөд шүүхийн тогтолцоо шүүх шинжилгээний үр дүнд тогтоогдсон нотлох баримтыг үнэлэх, ойлгох чиглэлд хангалттай мэдлэг туршлагагүй байгааг засахад анхаарах нь зүйтэй” зэрэг олон ач холбогдол бүхий санал, зөвлөмжийг дэвшүүлсэн нь олон улс даяар эдгээр асуудлыг авч үзэх шаардлагыг нөхцөлдүүлсэн. Тухайлбал, Их Британид 2011 онд “Шүүх шинжилгээний талаарх судалгаа, хөгжлийн асуудал” сэдвээр судалгаа хийгдсэн байна³.

¹ Сангийн сайдын 2015 оны 348 дугаар тушаалын хавсралт, Байгууллагын эрсдэлийн удирдлагад дотоод аудитыг нэвтрүүлэх заавар, УБ., 2015 он.

² Судалгаа нь Strengthening Forensic Science in the United States: A Path Forward нэртэй.

³ Ross, Alastair, Forensic Science in Australia: Where does Australia sit in relation to Trends and Issues in the International Context?, Current Issues in Criminal Justice, Volume 24/No.1, p.121

"Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн 44 дүгээр зүйлийг^{1 2} үндэслэн Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 63 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны харьяа "Шүүх эмнэлгийн магадлах төв", Сангийн сайдын дэргэдэх "Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо", Цагдаагийн ерөнхий газрын "Шинжилгээний хүрээлэн"-г нэгтгэн Хууль Зүй Дотоод Хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Шүүхийн шинжилгээний үндэсний төв"-ийг байгуулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, нэгдсэн эмнэлгийн эмч нарыг нэгтгэн "Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай" 270 дугаар тогтоол гарч, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 67, 68 дугаар тогтоолоор Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний алба тохируулагч агентлагийн статустай ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын тухайд 2013 оноос эрсдлийн үнэлгээ хариуцсан тусгайлсан орон тоо баталсан бөгөөд үйл ажиллагаа нь жил ирэх тутам жигдрэн олон улсын стандартад нийцэн ажиллахыг зорьсоор байна. Шүүхийн шинжилгээний байгууллагад учирч болох эрсдэлийг онолын үүднээс дараах хэсгүүдээр тодорхойллоо. Үүнд:

1. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл;
2. Үйл ажиллагааны эрсдэл;
3. Төсөв, санхүүгийн эрсдэл.

Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл

Монгол улсад "Шүүхийн шинжилгээний тухай"³ хууль 2009 оны 12 сарын 3-ны өдөр батлагдан тус хуулиар шүүхийн шинжилгээ хийх үндэслэл, журам, зарим төрлийн шинжилгээний онцлог болон шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, шинжээчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан нь тус салбарт анх удаа бие даасан эрх зүйн орчин бүрдэх таатай нөхцөл болсон юм.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 9 жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд тус хуульд нийтдээ 5 удаа нэмэлт, өөрчлөлт хийсэн байна. Эдгээр өөрчлөлтийн тухайд уг

¹ Тус хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан.

² "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн 44 дүгээр зүйлд "хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх прокурор болон хууль сахиулах бусад байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой криминалистик, шүүх-эмнэлэг, санхүү нягтлан бодох бүртгэл зэрэг шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, нэгдсэн зохион байгуулалтад оруулан материаллаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээ авна" гэж заасан.

³ <http://www.legalinfo.mn/law/details/88?lawid=88>

хуулийн агуулга, үзэл баримтлалыг өөрчлөхөд бус, харин бусад хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулж хийгдэж байсан өөрчлөлтүүд байна.

Энэ хууль батлагдсанаар шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндэс бүрдэхэд чухал ач холбогдолтой болсон боловч практикт зарим тулгамдсан асуудал /эрсдэл үүсч болох/ гарсаар байна¹. Тухайлбал,

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 24-27 дугаар зүйлд зарим төрлийн шинжилгээний онцлогийг тусгасан. Эдгээрт криминалистик, шүүх эмнэлэг, сэтгэц болон эдийн засгийн шинжилгээний төрлүүд хамаардаг. Энэ нь одоогийн шүүхийн шинжилгээнд чухал байр суурийг эзэлж байгаа боловч нийгэм, эдийн засгийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, хот суурин газрын төвлөрөл зэргээс хамааран сүүлийн үед гарч буй гэмт хэрэгт байгаль экологийн, цахим төхөөрөмжийн, инженер техникийн гэх мэт шинэ төрлийн шинжилгээг хийх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Үүнээс үүдэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн бодит байдлыг тогтоохын тулд дээр дурдсан шинэ төрлийн шинжилгээг хуульд нарийвчлан тусгаж өгөх шаардлага бий болсон нь харагдаж байна.

Мөн Шүүхийн шинжилгээний байгууллага нь Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасны дагуу криминалистик, шүүх эмнэлэг, сэтгэц, эдийн засаг болон тусгай төрлийн шинжилгээг хийж, дүгнэлт гаргаж байна. Мөн хуульд заасны дагуу шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зүгээс дээр дурдсан шинжилгээг хийж, дүгнэлт гаргах хугацааг тогтоохдоо тухайн шинжилгээний төрөл, хэлбэр, онцлог зэргийг харгалзан үзэлгүй, шинжилгээний төрөл бүрд нийтлэг хугацааг^{1 2} тогтоож байгаа нь шинжилгээний дүгнэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэл учирч байна. Өөрөөр хэлбэл, нэг талаас шинжилгээ хийлгэхээр шинжээч томилж буй эрх бүхий этгээд нь тухайн шинжилгээний төрөл, онцлог, цар хүрээ болон шинжилгээнд ирүүлж буй объектын тоо хэмжээ, чанар зэргийн талаар нарийн мэдлэг, мэдээлэл байхгүйн улмаас эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэлгүйгээр бодит байдалд нийцтэй бус, шинжилгээ хийн дүгнэлт гаргаж амжаааргүй хугацааг тогтоож байна. Нөгөө талаас мөрдөгч, прокурор, шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг тал гэдэг утгаар зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлан шинжилгээний хугацааг тогтоож байна.

Энэ талаар зарим судлаачид өөрийн бүтээлдээ дурдсан байна. Тухайлбал, судлаач Т.Очирбат "...энэ нь амьдралд хэрэгжихэд төвөгтэй байгаа нь анзаарагддаг. Учир нь шинжээч томилж буй албан тушаалтан тухайн шинжилгээний цар хэмжээ,

¹ ХЗҮХ, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээний тайлан, УБ., 2018 он, 3 дахь тал.

² Шинжилгээ хийх хугацааны талаар Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйл, "Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүрэм" -ийн 3 дугаар зүйл, "Криминалистикийн шинжилгээ хийх журам" -ын 7 дугаар зүйл, "Эдийн засгийн шинжилгээ хийх журам" -ын 3 дугаар зүйл, "Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам" -ын 4 дүгээр зүйлд тус тус заасан.

онцлогийн талаар мэдлэг муутай, нөгөө талаар шинжээчдийн ажлын ачаалалтай холбоотойгоор хууль зөрчигдөх байдал харагдаж байна."¹ гэжээ.

Иймээс тухайн шинжилгээний төрөл, хэлбэр, онцлог, цар хүрээ зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр шинжилгээ хийх хугацааг харилцан адилгүй байдлаар тогтоож өгөх нь шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийх зарчмыг хангахад чухал ач холбогдолтой.

Түүнчлэн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8.4-т “Шинжилгээ хийх журмыг шинжилгээний төрлөөс хамааран хууль зүйн, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. Мөн хуулийн 12.1-т “Шинжээч нь хүлээн авсан шинжилгээний объектыг гэрэл зураг болон бусад арга хэрэгслээр бэхжүүлэн авсны дараа батлагдсан аргачлалын дагуу шинжилгээ хийнэ” гэж тусган эдгээрт нийцүүлсэн журмуудыг гаргасан боловч эрсдэл, хөдөлмөр хамгааллын чиглэлийн журам гаргаагүй байна.

Үйл ажиллагааны эрсдэл

Энэ бүлэг эрсдэлд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хэд хэдэн төрлийн эрсдэл байгаа хэдий ч энэхүү судалгааны ажилдаа албан хаагчдад нэн тэргүүнд тулгамдаж буй асуудлыг хөндөн бичлээ.

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2017 онд 65525 шинжилгээ хийсэн байна^{1 2}. Нийт шинжилгээг чиглэлээр нь авч үзвэл 58,1 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 21,4 хувийг хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ, 20,1 хувийг криминалистикийн шинжилгээ, 0,3 хувийг эдийн засгийн шинжилгээ эзэлж байна. Үүнээс үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээний 58,1 хувийг шүүх эмнэлэг дангаараа хийж байгаа нь тус салбарын эмч, шинжээчдийн хэрэгцээ шаардлага нийгэмд их байгааг харуулж байна.

Зураг 1. Шинжилгээний чиглэл



¹ Т.Очирбат, “Шүүхийн шинжилгээний байгууллага болон хууль сахиулах бусад байгууллагуудын ажлын уялдаа, эрх зүйн зохицуулалт, хүний нөөц, техник, технологийн асуудал”, Гэмт явдалтай тэмцэх асуудал №2-60 (2017): 91-92 дахь тал.

² Шүүхийн шинжилгээний статистик тайлан, 2017 он.

Хүснэгт 1. Шинжилгээний тоон үзүүлэлт

Шинжилгээний төрөл	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Цогцост хийгдсэн шинжилгээ	2811	3479	3767	4267	3521	3742	3686	3685
Хүний биед хийгдсэн шинжилгээ	20746	20835	23183	26249	29370	31535	31477	30168
Хэргийн материалаар хийгдсэн шинжилгээ	983	944	1073	1165	1200	1360	1555	1716
Нийт	27496	29049	31941	36151	38103	41242	41411	40423

Дээрх статистик мэдээллээс үзэхэд 2009 оноос хойш жил ирэх тутам шинжилгээний тоон үзүүлэлт өссөн дүнтэй байгааг харж болно. Энэ нь нэгж шинжээч эмчийн ажлын ачаалалтай харьцуулахад хүн амын суурьшил, нутаг дэвсгэрийн хэмжээ, зам харилцаа, гэмт хэргийн гаралт зэрэг олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байгааг харуулж байна. Мөн жилд дунджаар Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт цогцост хийсэн шинжилгээ 80-85, хүний биед хийсэн шинжилгээ 600-650, хэргийн материалын шинжилгээ 100-120 хийдэг байна. Үүнээс үзэхэд Шүүх эмнэлгийн шинжээчийн ажлын ачаалал өндөр байгаа болох нь харагдаж байна.

Үүнээс гадна Шүүх эмнэлгийн шинжээчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа өөр нэгэн хүчин зүйл бол шинжээч эмч нарын гаргасан дүгнэлтийг хохирогч, холбогдогч талын аль нэг нь хүлээн зөвшөөрөхгүй байх, прокурор эсхүл мөрдөн байцаагчийн санаачилгаар гэх мэт олон шалтгааны улмаас шинжээч эмчийн дүгнэлтийг дахин давтан бүрэлдэхүүнтэйгээр гаргах шаардлагатай болдог байна. Иймээс нэг талаас шинжээч эмч нарын ажлын ачааллыг харгалзах, нөгөө талаас бүрэлдэхүүнтэй хийгдэх шинжилгээний тоо, нөхцөл байдлыг харгалзан Шүүх эмнэлгийн шинжээч эмч нарын ажлын ачааллыг бууруулах талаар анхаарах шаардлагатай тулгарч байна.

Мөн Шүүхийн шинжилгээний байгууллагад сэтгэл зүйч болон эрүүл ахуйч эмч байхгүйгээс ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал¹, эрүүл ахуйн дэглэм алдагдаж алба хаагчид осол, гэмтэл, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчин /сэтгэл зүйн/, халдварт өвчинд өртөх эрсдэл тулгардаг.

Төсөв, санхүүгийн эрсдэл

Тус байгууллагын нийт төсвийг авч үзвэл 70.2 хувийг цалин, нийгмийн даатгалын зардал, 2.4 хувийг байр ашиглалтын зардал, 7.8 хувийг урсгал шилжүүлэг, 19.6 хувийг бусад зардал эзэлж байна. Батлагдсан төсөвт эзлэх зардлын ангиллаар авч үзвэл 2013 онд цалин, нийгмийн даатгалын зардал 76 хувь, 2014, 2015 онд 85,5 хувь, 2016 онд 76,5 хувь, 2017 онд 70,2 хувь байна. Өнгөрсөн онуудад хөрөнгө оруулалт бараг хийгдээгүй ба 2015 онд 253,4 сая төгрөгөөр тоног төхөөрөмж авсан байна. Үүнээс үзэхэд нийт төсвийн ихэнх хувийг цалингийн зардал эзэлж байгаа бөгөөд

¹ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 зүйлийн 27.2-т "Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна." гэж тусгасан.

тоног төхөөрөмжийн шинэчлэл, хөрөнгө оруулалт хийгдээгүй нь үндсэн чиг үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болгоход хүргэж байна.¹

Шүүхийн шинжилгээний байгууллагын төсөв, санхүүжилттэй холбоотой өөр нэгэн тулгамдсан асуудал бол шүүхийн шинжилгээний төв байрыг нүүлгэх эсэх асуудал юм. Хотын төвийн А зэрэглэлийн байршилд байрлаж байгаа шүүх эмнэлэгт улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн хохирогч нар ирж үзүүлдэг, нас барсан тохиолдол болгонд задлан шинжилгээ хийгддэг. Тухайлбал, ДОХ, сүрьеэ, тарваган тахал гэх мэт халдварт өвчнөөр амиа алдсан иргэдийг авчирч шинжилгээнд оруулдаг. Магадгүй эндээс халдварт өвчин нийслэл хотод тархахыг үгүйсгэхгүй. Тиймээс шүүх эмнэлгийн задлан шинжилгээ болон цогцос хадгалах өрөө, зарим лабораторийг хотын захад шилжүүлэхэд анхаарах шаардлагатай.²

Тус байгууллагад тулгарч байгаа өөр нэгэн асуудал бол зарим аймаг, орон нутгийн алба, хэсэг өөрийн байргүй байгаа явдал юм. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн мэдээллээр 2017 оны байдлаар 8 аймаг өөрийн байртай бөгөөд бусад алба, хэсэг түрээсийн болон цагдаагийн газар, хэлтэстэй хамт нэг байранд ажиллаж байна. Үүнээс үзэхэд нийт улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй алба, хэсгүүдийг өөрийн байртай болгоход анхаарал хандуулах шаардлагатай болох нь харагдаж байна.³

Мөн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг авч чадахгүйтэй холбоотой техник технологийн хоцрогдолд орж, зарим нэр төрлийн шинжилгээг хийж чадахгүй байх, эд мөрийн баримт үгүй болох зэрэг эрсдэл гарч байна.

Албаны байр болон зориулалтын лаборатори байхгүйгээс болон нормын хувцас, хөдөлмөр хамгаалал, халдваргүйжүүлэлтийн хувцас хэрэгслийг хангаж чадахгүйгээс албан хаагчдын эрүүл мэнд эрсдэлд орж, халдварт өвчин авах эрсдэл үүсч байна.

Түүнчлэн авто машины шатахууны зардал хүрэлцдэггүй, жолоочийн орон тоо байдаггүй зэргээс шалтгаалж албаны шуурхай бэлэн байдал алдагдах нөхцөл бүрдсэн, дотоод албан томилолтын зардал дутуу батлагдсанаас болж албан хаагчид томилолтын хугацааны зардлаа бүрэн авч чадахгүй зохих хэсгийг хувиасаа гарган ажиллах тохиолдлууд гарч байна.

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг давтан мэргэшил дээшлүүлж, хөгжүүлж чадахгүй, мөн өндөр ур чадвартай, нарийн мэргэжлээр төгссөн албан хаагчдыг орчин үеийн техник багаж, хэрэгслээр хангаж чадахгүй байгаагаас гадна орон тооны хүрэлцээгүй байдлаас болж албан хаагчид өндөр ачаалалтай ажиллаж байна.

¹ Шүүхийн шинжилгээний байгууллагын батлагдсан төсвийн товч танилцуулга, 2017 он.

² Алтанхишиг, "Шүүхийн шинжилгээний байгууллагын түүхэн хөгжил, хөгжлийн чиг хандлага, үйл ажиллагаанд тулгамдсан асуудал", Шүүхийн шинжилгээ эмхэтгэл, Дугаар 4, (2017), 5 дахь тал.

³ Мөн тэнд.

Иймээс Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасан “Шүүхийн шинжилгээний байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэх талаар хууль тогтоогчид анхаарах шаардлагатай.

Дүгнэлт

Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг бодлогын түвшинд зорилт болгон хэрэгжүүлж, байгууллагын эрсдэлийн удирдлагын олон улсын зарчим, стандартуудыг нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Тус байгууллагад төсөв, санхүүтэй холбоотой хүндрэлүүд тухайлбал, эд хөрөнгө дутсан үрэгдсэн, байгаа эд хөрөнгө шаардлага хангахгүй байх зэргээс үйл ажиллагаанд доголдол үүсэх, мөнгө хөрөнгө дутсан, алдагдал хүлээсэн, нөөцгүй болсоноос өдөр тутмын санхүү төлбөр тооцоонд саатал гарах, орон тоо хангалтгүй, эсхүл ур чадвар дутмаг, боловсон хүчин дутагдалтай байхаас ажлын ачаалал ихсэх зэрэг тулгамдаж буй эрсдэл байна.

Эрсдэлийн талаар хийсэн судалгаа, холбогдох тайлан, бичиг баримтуудыг судлан үзсэний үндсэн дээр Шүүхийн шинжилгээний байгууллагад тулгарч буй эрсдлүүдийг дараах төрлөөр /аспектаар/ авч үзэн тэдгээрийг бууруулах эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

- Шүүхийн шинжилгээний байгууллагын бодлогыг хэрэгжүүлэх явцад үүсч болох эрсдэл;
- Эрх зүйн орчны хүрэн дэх эрсдэл;
- Бүтэц зохион байгуулалтын эрсдэл;
- Хүний нөөцийн эрсдэл;
- Техник технологийн үйл явцын эрсдэл;
- Шинжилгээний арга зүйн хүрээний эрсдэл;
- Эдийн засаг, санхүүгийн эрсдэл;
- Шинжээчийн аюулгүй байдлын орчны эрсдэл;
- Стресс, сэтгэцийн болон бусад эмгэг үүсэх эрсдэл.

Санал

Дээрх үүсч болох болон үүсээд байгаа эрсдэлийг харгалзан түүнийг даван туулах дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл

- Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 24-27 дугаар зүйлд тусгасан зарим төрлийн шинжилгээний төрлөөс гадна шинэ төрлийн шинжилгээний төрлүүд болох байгаль экологийн, цахим төхөөрөмжийн, инженер техникийн гэх зэрэг шинжилгээний төрлийг Шүүхийн шинжилгээний тухай хуульд нарийвчлан тусгах;
- Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болох мөрдөгч, прокурор, шүүгч. шүүх болон хуульд заасан төрийн эрх бүхий байгууллагын зүгээс бүх төрлийн

шинжилгээний хугацааг 3-5 хоногийн хугацаатайгаар тогтоож байгаа нь нэг талаас эдгээр субъектэд шинжилгээний хугацааг тогтоох давуу эрхийг хуулиар олгосонтой холбоотой бол нөгөө талаас шинжилгээний хугацааг тогтоохдоо шинжилгээ хийж, дүгнэлт гаргах боломжтой жишиг хугацааг харгалзан үзэх, эсхүл тухайн мэргэжлийн байгууллага, түүний удирдлагаас санал болгож буй зөвлөмжийг зайлшгүй харгалзан үзэх талаар Шүүхийн шинжилгээний тухай хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаагаар холбоотой юм. Иймд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацаатай холбогдон практикт гарч буй эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд шинжилгээ хийх хугацааг тухайн шинжилгээний төрөл, онцлогоос хамааран хуулиар тусгайлан зохицуулж өгөх шаардлагатай;

- шүүхийн шинжилгээний хугацаа тодорхой бус, зарим тусгай мэдлэг шаардагдах шинжилгээг хэрхэн хийх талаарх зохицуулалт хуульд тодорхой бус, шүүхийн шинжилгээний ажилтан, албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, мөн шинжээчийн хараат бус байдлыг хангах зэрэг шаардлагатай зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах;

- Мөн хуульд нийцүүлэн зарим журмыг батлан гаргах шаардлагатай.

Хоёр. Үйл ажиллагааны эрсдэл

- Шинжээчдийг техникийн болон бусад мэдлэгийн салбараар мэргэшүүлж бэлтгэх ажил чухал байна. Мэдээллийн технологийн, эдийн засгийн, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийг шинжилгээний арга зүйд сурган бэлтгэх замаар дээрх асуудлыг шийдвэрлэх;

- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тоог шинэчлэн нэмэгдүүлэх. Тухайлбал, нийслэлийн зарим дүүргүүдэд Цагдаагийн 2, 3 дугаар хэлтсүүд байгуулагдсантай холбогдуулан криминалистикийн шинжээчийн орон тоог нэмэх, аймгийн Шүүхийн шинжилгээний албадад лабораторийн буюу хими, биологийн шинжээчийн орон тоог шинээр батлуулах, зарим аймгийн алслагдсан сумдад Шүүхийн шинжилгээний хэсэг байгуулах;

- Стресс, сэтгэцийн болон бусад эмгэг үүсэх эрсдэл өндөр байгааг харгалзан урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, эрүүлжүүлэх ажлыг бодлогын түвшинд авч үзэн, тусгай хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх /албан хаагчдад үйлчлэх сэтгэл зүйчтэй болох/;

- Албан хаагчид эрүүл мэндэд хортой нөхцөлд ажиллаж байдаг тул тэдний эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар анхаарч ажиллах.

Гурав. Төсөв, санхүүгийн эрсдэл

- Улсын төсвөөр бүрэн санхүүжилт хийх бололцоо дутмаг байдаг тул гадаадын төсөл, хөтөлбөртэй хамтран санхүүжилт хийх бололцоогоор хангах;

- Төсөв батлагдахад лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, шинээр тоног төхөөрөмж худалдан авах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зардлыг хангалттай тусгаж өгөх;

- Шинжилгээний объектыг хадгалах, хамгаалах зориулалтын байр, савны асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх;

- Шүүхийн шинжилгээний албадад жолоочийн орон тоо батлагдаагүй тул алсын дуудлагад шинжээч бусад албан хаагчид авто машин жолоодох, батлагдсан шатахууны төсөв хүрэлцээгүй байгааг анхаарч шийдвэрлэх;

-Албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын зардал, төсвийг шийдвэрлэх.

*Ц.Мөнхбаяр -ХСИС, Хууль сахиулахын
удирдлагын академийн 8022-р дамжааны
суралцагч, цагдаагийн хошууч*

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨГДЭЭШЛҮҮЛЭХ нь

Хураангуй: Энэхүү илтгэлээр шүүхийн шинжилгээний байгууллагад язохион байгуулагдаж байгаа албаны болон мэргэжлийн сургалтын өнөөгийн байдал тулгамдсан асуудлуудыг судалж цаашид алба хаагч бүрт цаг үетэйгээ зэрэгцсэн, бодит үр нөлөө бүхий сургалт явуулах, сургалтын үйл явцыг боловсронгуй, хүртээмжтэй болгох боломжийг эрэлхийлсэн болно.

Түлхүүр үгс: “Шүүхийн шинжилгээ” гэж эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, түүх, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааг;

“**шинжээч**” гэж шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн этгээдийг;

“**шүүхийн шинжилгээний мэргэжилтэн**” гэж криминалистикийн болон эмнэлгийн тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох эрх бүхий, шинжилгээний байгууллагын ажилтныг;

“**шинжээчийн дүгнэлт**” гэж шинжээч өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд хийсэн шинжилгээний явц. үр дүнг тусгасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг;

“**шинжилгээний магадлагаа**” гэж тусгай мэдлэг бүхий мөрдөгч ул мөр, эд мөрийн баримт болон хэргийн бусад материалд анхан шатны үзлэг оношилгоо хийж, үр дүнг тусгасан баримт бичгийг;¹

¹Шүүхийн шинжилгээний тухай хууль